



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 БАГА БОЛОВСРОЛ

5  
АНГИ

# МОНГОЛ ХЭЛ

БАГАНАН КОД  
НААХ ХЭСЭГ

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....



## САНАМЖ

- Эхийг уншаад, даалгаврыг зааврын дагуу гүйцэтгээрэй.
- Даалгаврыг 40 минутад гүйцэтгэнэ үү.
- Өгсөн зайд цэвэр гаргацтай бичээрэй.

### Цасан цэцэг

Нохой дахин хуцлаа. Миний үнэрийг авснаас зайлхагүй гэж зараа бодоод ойн цагдаагийн байшингаас холдов. Цас лавсан орсоор л ой, дундуур ганцаар явах нь уйтгартай байлаа.

Зарааны дотор сонин бодол орж ирлээ. Цасан хунгар дээр авирч гараад хaa нэгтээ цасан цэцэг ургадаг сан бол түүнийг түүж авчраад ойн чөлөөнд тавибал туулай, бамбарууш, дудран яласан их баярлах бол? хэмээн бodoх зуур өвгөн гацуур цагаан малгайгаа авч,

- Тийм цэцэг хaa ургадгийг би мэднэ. Хоёр зуун нарсны цаанаа, налуу эргийн дэргэд хөлддөггүй нэгэн булаг бий. Дунд нь мөс тогтсон нэг хожуул байгаа. Түүн дээр нөгөө цэцэг чинь бий гэж хэлээд цагаан малгайгаа яах ийхийн зуургүй өмсөв.

Зараа хэлсэн ёсоор нь хүрч очвол гайхмаар гоё шидэт цасан цэцэг ургасан байлаа. Нил цэцэг ч юм шиг тансаг сайхан өнгөөрөө нүд булаана. Зараа түүнийг таслан авч чадсангүй. Усанд харайн орж үндэснээс нь оролдож тасальяа хэмээн бодлоо. Усанд шумбан ортол цэцгийн үндэс харагдсангүй. Зараа уснаас гарч ирээд харвал шидэт цэцэг байдгаараа байлаа. Хачин юм даа. Хөлддөггүй булагт долоон удаа шумбасан ч цэцэг таслан авах хүсэл нь биелсэнгүй.

Тэр замдаа булгийн усанд норсон биеэрээ шинэхэн цасан дээр өнхөрч хөлбөрч явлаа.

Ойн цоорхойд хөгжим сонсогдож бамбарууш, дудран, туулайнууд мөнгөн гацуураа тойрон бүжиглэж байлаа. Дудран дуу алдаж,

- Пээ ямар гоё цасан цэцэг вэ? гэхэд бамбарууш
- Жинхэнэ цасан цэцэг, шидэт цасан цэцэг, амьд цасан цэцэг. Даанч зараа найз маань энд алга байна гээд цэнгэн бүжиглэсээр байв.

Зараа хэдийгээр “Би энд байна” гэж хашхирч хэлэхийг хүссэн ч даарч бээрсэндээ болоод ганц ч уг хэлж чадсангүй.

1 Эхийн гол хэсэгт цас маш их орж байгааг илэрхийлсэн өгүүлбэр аль нь вэ?

- А. Жинхэнэ цасан цэцэг, шидэт цасан цэцэг, амьд цасан цэцэг.
- Б. Түүн дээр нөгөө цэцэг чинь бий гэж хэлээд цагаан малгайгаа яах ийхийн зуургүй өмсөв.
- В. Тэр замдаа булгийн усанд норсон биеэрээ шинэхэн цасан дээр өнхөрч хөлбөрч явлаа.
- Г. Цас лавсан орсоор л ой дундуур ганцаар явах нь уйтгартай байлаа.

2 Уран сэтгэмж бүхий доорх хэсгийн бодит байдлыг дүрсэлсэн өгүүлбэрийг эхээс олж бичээрэй.

.....Хүрч очвол гайхмаар гоё шидэт цасан цэцэг ургасан байлаа. Нэг харахад нил цэцэг ч юм шиг тансаг сайхан өнгөөрөө нүд булаана.



.....  
.....  
.....



3 Аль нь хүншүүлсэн дүрслэл вэ?  гэж тэмдэглэнэ үү.

Миний үнэрийг авснаас зайлхагүй гэж зараа бодоод ойн цагдаагийн байшингаас холдов.

Хөлддөггүй нэгэн булаг бий. Дунд нь мөс тогтсон нэг хожуул байгаа.

Өвгөн гацуур цагаан малгайгаа авч, Тийм цэцэг хaa ургадгийг би мэднэ.

4 Доорх үйл хөдлөлд тохирох шалтгааныг эхээс олж бичээрэй.

Яагаад?

Зараа хөлддөггүй булагт долоон удаа шумбасан



.....  
.....  
.....

5 А. Зараа яагаад цасан цэцгийг таслахыг хүссэн бэ?  гэж тэмдэглэнэ үү.

Цасан цэцэг маш гоё өнгөтэй байсан учир

Найзуудаа баярлуулахыг хүссэн учир

Мөнгөн гацуураа чимэхийг хүссэн учир

Б. Учир шалтгааныг батлах өгүүлбэрийг эхээс сонгон бичээрэй.

6 Зохиолч “Цасан цэцэг” эхээр дамжуулан ямар санааг гаргасан бэ? Доорх санаануудыг чухлаас нь эхлэн дугаарлаарай.

- Амьтад ч гэсэн найзalж, нөхөрлөж нэгэндээ түшиг болон амьдардаг.
- Байгальд олон өөр өөр үзэгдэл байдаг.
- Улирал бүр онцлогтой өөрийн гэсэн өнгө төрхтэй.
- Цас орж ихээр орж байгаа нь байгалийн үзэсгэлэнг улам тодосгон харуулж байна.

7 Аль урилгад тодруулсан үгийг зөв бичсэн байна вэ?  гэж тэмдэглэнэ үү.

Урилга

Эрхэм хүндэт найз минь  
Төрсөн **өдөрийн** баярт  
хүрэлцэн **ирэхийг** урьж  
байна.

Урилга

Эрхэм хүндэт найз минь  
Төрсөн **өдрийн** баярт  
хүрэлцэн **ирэхийг** урьж  
байна.

Урилга

Эрхэм хүндэт найз минь  
Төрсөн **өдрийн** баярт  
хүрэлцэн **ирхийг** урьж  
байна.



8

Дараах үйл явдал зуны улиралд яж өрнөхийг төсөөлөн бичээрэй. (Үгийн тоо 60 – 70)

Зараа хэлсэн ёсоор нь хүрч очвол гайхмаар  
гоё шидэт цасан цэцэг ургасан байлаа.  
Зараа түүнийг таслан авч чадсангүй.





Засалтын хүснэгт

Даалгаврын дугаар	Авсан оноо
I	
II	
III	
IV	
V	
VI	
VII	
VIII	A
	Б
	В

